



АЙМАГ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44а,

Утас: 26-21-09, Факс: (976-51) 26-27-37,

E-mail: info@nac.gov.mn, http://www.nac.gov.mn

2017.04.25 № 01/229
танай _____-ны № _____-т

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 37, 39, 40 дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Хорооны Насанд хүрээгүй этгээд холбогдсон хэргийг байцаан шийтгэх ажиллагаа дахь хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх 10 дугаар зөвлөмжийн хүрээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт Аймаг, дүүргийн Засаг дарга, орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороо байгуулах асуудлыг хуульчилсан билээ.

Тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасны дагуу 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/51, А/69 дүгээр хамтарсан тушаалаар “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам” батлагдаад байна.

Иймд аймаг, шаардлагатай тохиолдолд сум дундын шүүх ажиллаж буй сумдад Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 2017 оны 5 дугаар сарын 15-ны дотор байгуулж, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, тайланг журмын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу хагас жил тутам Хүүхдийн төлөө зөвлөлөөр хэлэлцэж ажлын алба болох аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ажлын албанд ирүүлж байхыг хүсье.

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын дагуу Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлье.

Хувийг: Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст

ДАРГА



О.АЛТАНСҮХ

0000590